



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 524

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр 1, 2, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хил хамгаалах ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 179,800,000.00 (нэг зуун далан есөн сая найман зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 22,474,999.95 (хорин хоёр сая дөрвөн зуун далан дөрвөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Бүгд Найрамдах Киргиз улсын нийслэл Бишкек хот дахь Монгол Улсын Элчин сайдын яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хил хамгаалах ерөнхий газрын дарга бригадын генерал Х.Лхагвасүрэн, Бүгд Найрамдах Киргиз улсын нийслэл Бишкек хот дахь Монгол Улсын Элчин сайд С.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



Хил хамгаалах ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз улсын нийслэл
Бишкек хот дахь Элчин сайдын яаманд балансаас
балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Лексус LX-570, 86-66 УАЕ	2020	179,800,000.00	22,474,999.95	157,325,000.05
	Нийт дүн		179,800,000.00 (нэг зуун далан есөн сая найман зуун мянган)	22,474,999.95 (хорин хоёр сая дөрвөн зуун далан дөрвөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн таван мөнгө)	157,325,000.05 (нэг зуун тавин долоон сая гурван зуун хорин таван мянга таван мөнгө)